



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 79


Гадаадад зээлээр суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорж овогтой Гэрэлтуяаг Эрүүл мэндийн яамны захиалгаар Австрали Улсын Curtin Технологийн их сургуулийн магистрантурт эм зүйн чиглэлээр, Монхоо овогтой Ганжигүүрийг Сангийн яамны захиалгаар АНУ-ын Johnson&Wales их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 292 дугаар тушаалын дагуу АНУ-ын Columbia коллежид суралцаж буй Пүрэвдорж овогтой Нансалын суралцах хугацааг 1 жилээр сунгасугай.

4. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Handwritten signature

Ё.ОТГОНБАЯР